НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2022/286/НА-СА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2022 он | Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга, аудитын менежер: З.Мөнхбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цогбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: : tsogbayara@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Я.Алтанцэцэг<br>Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Аудитор: Б.Тэгшлхам<br>Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ........ 3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5-14
3. Аудитын тайлан ........ 15
   3.1 Ерөнхий зүйл ........ 15
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 15
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 16
   3.4 Материаллаг байдал ........ 16
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 16-18
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 19-21
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 22
   3.8 Аудитын гол асуудал ........ 23
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 24
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 25
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 25
4. Аудитын илрүүлэлт ........ 25-28
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 29-30

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НИТХ | Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НЗДТГ | Нийслэлийн Засаг даргын тамгын газар |
| НЗД | Нийслэлийн Засаг дарга |
| НӨХК | Нийслэлийн өмч хувьчлалын комисс |
| НӨАУГ | Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар |
| УСУГ | Ус сувгийн удирдах газар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.02.25 № 563

танай ____________-ны №____________-т

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН
ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГА
М.БАЯРАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

002000635

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,905,916,064.64** | **2,189,247,794.30** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,484,976,935.49 | 1,614,969,960.81 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 1,484,976,935.49 | 1,614,969,960.81 |
| **3121** | **Төгрөг** | 1,484,976,935.49 | 1,614,969,960.81 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,484,976,935.49 | 1,614,969,960.81 |
| **33** | **АВЛАГА** | 372,140,929.15 | 532,518,172.49 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 3,920,000.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 338,140,879.15 | 528,537,330.15 |
| **335** | **Бусад авлага** | 34,000,050.00 | 60,842.34 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 34,000,050.00 | 60,842.34 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 48,798,200.00 | 41,759,661.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 48,798,200.00 | 41,759,661.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 13,414,766.00 | 10,951,131.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,524,084.00 | 3,921,928.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 415,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,755,000.00 | 205,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 29,104,350.00 | 26,266,602.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **38,894,184,612.71** | **30,708,533,465.90** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 38,894,184,612.71 | 30,708,533,465.90 |
| **392** | **Биет хөрөнгө** | 38,541,754,172.71 | 30,356,103,025.90 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 42,008,372,547.05 | 35,111,294,514.52 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -4,155,294,563.71 | -5,112,281,055.34 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 98,475,742.00 | 125,255,186.90 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -70,147,417.52 | -85,104,522.88 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 323,994,012.00 | 220,183,027.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -213,157,693.80 | -181,281,607.71 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 149,386,254.37 | 117,276,989.37 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -60,227,455.86 | -72,664,071.26 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 283,283,678.58 | 42,167,678.58 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 738,732,206.00 | 738,732,206.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -450,056,747.00 | -524,767,330.00 |
| 39217 | Ном | -111,606,389.40 | -22,707,989.28 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 352,430,440.00 | 352,430,440.00 |
| 39301 | Програм хангамж | 5,565,400.00 | 5,565,400.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,565,400.00 | -5,565,400.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 352,430,440.00 | 352,430,440.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **40,800,100,677.35** | **32,897,781,260.20** |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **967,213,615.99** | **214,053,653,501.43** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 718,538,156.99 | 75,552,496,581.17 |
| 412 | **Богино хугацаат зээлийн өглөг** | 702,654,756.99 | 75,264,230,381.17 |
| 4121 | **Төгрөг** | 702,654,756.99 | 75,264,230,381.17 |
| 41214 | Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл | 00.00 | 74,438,682,598.86 |
| 41217 | Санхүүгийн бусад байгууллага | 702,654,756.99 | 825,547,782.31 |
| 413 | **Өглөг** | 15,883,400.00 | 288,266,200.00 |
| 4136 | **Бусад өглөг** | 15,883,400.00 | 288,266,200.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 15,883,400.00 | 288,266,200.00 |
| 42 | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 248,675,459.00 | 138,501,156,920.26 |
| 422 | **Урт хугацаат зээл** | 248,675,459.00 | 138,501,156,920.26 |
| 4221 | **Төгрөг** | 248,675,459.00 | 138,501,156,920.26 |
| 42214 | Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл | 00.00 | 138,327,192,044.26 |
| 42216 | Арилжааны банк | 248,675,459.00 | 173,964,876.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **39,832,887,061.36** | **-181,155,872,241.23** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 39,832,887,061.36 | -181,155,872,241.23 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 21,484,417,253.54 | 21,484,417,253.54 |
| 51101 | Өмч: - төрийн | 21,484,417,253.54 | 21,484,417,253.54 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | -6,313,676,397.82 | -220,814,126,937.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -6,313,676,397.82 | -209,152,865,105.08 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -11,661,261,832.91 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 24,662,146,205.64 | 18,173,837,443.22 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **40,800,100,677.35** | **32,897,781,260.20** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **46,423,149,959.37** | **15,751,760,899.68** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **24,893,753,005.37** | **3,651,908,244.68** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 4,142,443,405.37 | 3,465,801,897.38 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,036,671,305.30 | 642,476,004.30 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,265,060.00 | 675,270.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,035,406,245.30 | 641,800,734.30 |
| 120005 | Түрээсийн орлого | 3,105,772,100.07 | 2,823,325,893.08 |
| 121 | **Хөрөнгийн орлого** | 20,751,309,600.00 | 186,106,347.30 |
| 121002 | Өмч хувьчлалын орлого | 20,751,309,600.00 | 186,106,347.30 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **21,529,396,954.00** | **12,099,852,655.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,488,254,912.00 | 9,285,568,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 278,205,184.00 | 649,205,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,210,049,728.00 | 8,636,363,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,240,354,400.00 | 1,389,352,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,240,354,400.00 | 1,389,352,400.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 7,800,787,642.00 | 1,424,931,955.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 7,800,787,642.00 | 1,424,931,955.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **45,911,222,537.24** | **21,555,709,333.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **33,610,434,895.24** | **20,130,777,378.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,089,192,139.31 | 6,038,935,988.62 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 901,520,871.47 | 872,156,289.14 |
| 210101 | Үндсэн цалин | 530,235,407.55 | 550,213,368.52 |
| 210102 | Нэмэгдэл | 228,505,940.99 | 173,061,491.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 71,407,896.60 | 78,108,599.00 |
| 210104 | Урамшуулал | 71,371,626.33 | 70,772,829.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 114,496,805.19 | 114,150,182.76 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 78,645,203.15 | 79,469,174.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,102,463.99 | 8,850,838.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,238,290.08 | 6,989,950.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,880,008.78 | 1,712,747.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,630,839.19 | 17,127,471.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,633,896.87 | 33,131,436.08 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,645,587.76 | 28,087,436.08 |
| 210304 | Байрны түрээс | 4,988,309.11 | 5,044,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,781,295.73 | 61,727,229.85 |
| 210401 | Бичиг хэрэг | 21,903,783.00 | 17,980,130.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,121,261.00 | 19,370,033.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,756,251.73 | 15,389,976.85 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 8,987,090.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 886,195,115.17 | 1,552,194,096.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 885,554,465.17 | 1,526,997,996.80 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 249,800.00 | 396,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 246,200.00 | 246,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 24,465,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,110,564,154.88 | 3,405,576,753.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 871,444,097.00 | 1,777,572,180.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,320,000.00 | 5,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 234,800,057.88 | 1,623,004,573.99 |
| **211** | **ХҮҮ** | 6,380,736,400.00 | 10,773,523,943.95 |
| **2111** | **Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр** | 00.00 | 4,752,428,443.95 |
| 211101 | Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр | 00.00 | 4,752,428,443.95 |
| **2112** | **Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр** | 6,380,736,400.00 | 6,021,095,500.00 |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 6,380,736,400.00 | 6,021,095,500.00 |
| **212** | **ТАТААС** | 23,975,941,114.68 | 3,071,426,075.38 |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | 23,975,941,114.68 | 3,071,426,075.38 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 23,975,941,114.68 | 3,071,426,075.38 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 164,565,241.25 | 246,891,371.03 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,002,475.00 | 27,189,440.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,225,555.00 | 17,234,712.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,776,920.00 | 9,954,728.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 138,562,766.25 | 219,701,931.03 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 138,562,766.25 | 219,701,931.03 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,300,787,642.00** | **1,424,931,955.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,300,787,642.00 | 1,424,931,955.00 |
| 220001 | Барилга байгууламж | 6,543,347,702.00 | 440,510,955.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 289,435,940.00 | 594,431,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,468,004,000.00 | 389,990,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **511,927,422.13** | **-5,803,948,434.30** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 00.00 | 1,314,051,270.51 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 00.00 | 1,314,051,270.51 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 548,932,484.87 | 7,171,364,669.12 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 548,932,484.87 | 7,171,364,669.12 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -548,932,484.87 | -5,857,313,398.61 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-37,005,062.74** | **-11,661,261,832.91** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 21,484,417,253.54 | 25,099,277,746.41 | -6,713,802,875.85 | 39,869,892,124.10 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 437,131,540.77 | 437,131,540.77 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **21,484,417,253.54** | **25,099,277,746.41** | **-6,276,671,335.08** | **40,307,023,664.87** |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -37,005,062.74 | -37,005,062.74 |
| **2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **21,484,417,253.54** | **24,662,146,205.64** | **-6,313,676,397.82** | **39,832,887,061.36** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -202,839,188,707.26 | -202,839,188,707.26 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **21,484,417,253.54** | **24,662,146,205.64** | **-209,152,865,105.08** | -163,006,301,645.90 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -6,488,308,762.42 | 00.00 | -6,488,308,762.42 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -11,661,261,832.91 | -11,661,261,832.91 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **21,484,417,253.54** | **18,173,837,443.22** | **-220,814,126,937.99** | -181,155,872,241.23 |

## Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **45,949,130,658.61** | **15,733,569,512.13** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **24,419,733,704.61** | **3,633,716,857.13** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,668,424,104.61 | 3,447,610,509.83 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,265,060.00 | 675,270.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,265,060.00 | 675,270.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 3,667,159,044.61 | 3,446,935,239.83 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 20,751,309,600.00 | 186,106,347.30 |
| 121002 | Өмч хувьчлалын орлого | 20,751,309,600.00 | 186,106,347.30 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **21,529,396,954.00** | **12,099,852,655.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,488,254,912.00 | 9,285,568,300.00 |
| 131103 | ЗГНХ.ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 278,205,184.00 | 649,205,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,210,049,728.00 | 8,636,363,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 9,041,142,042.00 | 2,814,284,355.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,240,354,400.00 | 1,389,352,400.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 7,800,787,642.00 | 1,424,931,955.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **33,341,619,786.36** | **13,764,389,564.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **33,341,619,786.36** | **13,764,389,564.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,820,377,030.43** | **4,424,976,617.97** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 896,485,846.45 | 872,156,289.14 |
| 210101 | Үндсэн цалин | 514,606,180.91 | 546,896,662.88 |
| 210102 | Нэмэгдэл | 235,735,262.32 | 175,329,468.31 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 74,611,612.22 | 78,191,099.00 |
| 210104 | Урамшуулал | 71,532,791.00 | 71,739,058.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 119,530,829.80 | 114,211,025.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,730,952.25 | 79,530,016.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,031,191.99 | 8,850,838.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,381,152.88 | 6,989,950.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,580,832.59 | 1,712,747.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,806,700.09 | 17,127,471.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,929,842.76 | 33,131,436.08 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,999,399.06 | 28,087,436.08 |
| 210304 | Байрны түрээс | 9,930,443.70 | 5,044,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,575,462.73 | 45,254,407.85 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,265,350.00 | 10,780,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,164,761.00 | 16,173,816.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,756,251.73 | 14,726,193.85 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,389,100.00 | 3,574,398.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 857,065,398.69 | 1,590,750,659.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 850,456,398.69 | 1,560,554,559.80 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 249,800.00 | 396,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 246,200.00 | 246,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 24,465,600.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 6,025,000.00 | 5,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 864,492,650.00 | 1,769,472,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 860,172,650.00 | 1,764,472,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,320,000.00 | 5,000,000.00 |
| **211** | **ХҮҮ** | **6,380,736,400.00** | **6,021,095,500.00** |
| **2112** | **Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр** | 6,380,736,400.00 | 6,021,095,500.00 |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 6,380,736,400.00 | 6,021,095,500.00 |
| **212** | **ТАТААС** | **23,975,941,114.68** | **3,071,426,075.38** |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | 23,975,941,114.68 | 3,071,426,075.38 |
| 212101 | Нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн | 23,975,941,114.68 | 3,071,426,075.38 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **164,565,241.25** | **246,891,371.03** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,002,475.00 | 27,189,440.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,225,555.00 | 17,234,712.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,776,920.00 | 9,954,728.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 138,562,766.25 | 219,701,931.03 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 138,562,766.25 | 219,701,931.03 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **12,607,510,872.25** | **1,969,179,947.75** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **12,787,562,942.35** | **1,839,186,922.43** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,787,562,942.35** | **1,839,186,922.43** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,787,562,942.35 | 1,839,186,922.43 |
| 220001 | Барилга байгууламж | 6,267,947,732.00 | 440,510,955.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 289,435,940.00 | 574,709,450.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 6,154,294,105.35 | 782,338,572.43 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 75,885,165.00 | 41,627,945.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-12,787,562,942.35** | **-1,839,186,922.43** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -180,052,070.10 | 129,993,025.32 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 1,665,029,005.59 | 1,484,976,935.49 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,484,976,935.49 | 1,614,969,960.81 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн /илүү+, дутуу-/ | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,746,518,000.00** | **1,229,321,202.97** | **-517,196,797.03** | 70% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,746,518,000.00** | **1,229,321,202.97** | **-517,196,797.03** | 70% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,717,675,400.00** | **1,202,131,762.97** | **-515,543,637.03** | 70% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,002,048,700.00** | **872,156,289.14** | **-129,892,410.86** | 87% |
| 210101 | Үндсэн цалин | 581,104,600.00 | 546,896,662.88 | -34,207,937.12 | 94% |
| 210102 | Нэмэгдэл | 270,552,800.00 | 175,329,468.31 | -95,223,331.69 | 65% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 78,650,000.00 | 78,191,099.00 | -458,901.00 | 99% |
| 210104 | Урамшуулал | 71,741,300.00 | 71,739,058.95 | -2,241.05 | 100% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **135,276,600.00** | **114,211,025.10** | **-21,065,574.90** | 84% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 95,194,600.00 | 79,530,016.65 | -15,664,583.35 | 84% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,020,500.00 | 8,850,838.99 | -1,169,661.01 | 88% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,016,400.00 | 6,989,950.83 | -1,026,449.17 | 87% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,004,100.00 | 1,712,747.03 | -291,352.97 | 85% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,041,000.00 | 17,127,471.60 | -2,913,528.40 | 85% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **35,483,400.00** | **33,131,436.08** | **-2,351,963.92** | 93% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,999,400.00 | 28,087,436.08 | -1,911,963.92 | 94% |
| 210304 | Байрны түрээс | 5,484,000.00 | 5,044,000.00 | -440,000.00 | 92% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **49,887,900.00** | **46,420,407.85** | **-3,467,492.15** | 93% |
| 210401 | Бичиг хэрэг | 10,780,000.00 | 10,780,000.00 | 0.00 | 100% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,174,400.00 | 16,173,816.00 | 584.00 | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,553,500.00 | 14,726,193.85 | -827,306.15 | 95% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,380,000.00 | 4,740,398.00 | -2,639,602.00 | 64% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **489,978,800.00** | **131,212,604.80** | **-358,766,195.20** | 27% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 453,782,700.00 | 101,016,504.80 | -352,766,195.20 | 22% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 396,300.00 | 396,300.00 | 0.00 | 100% |
| 210804 | Тээврийн хэрэгсэл татвар | 246,200.00 | 246,200.00 | 0.00 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 | 0.00 | 100% |
| 210807 | Газрын төлбөр | 24,465,600.00 | 24,465,600.00 | 0.00 | 100% |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 5,000,000.00 | 5,000,000.00 | 0.00 | 100% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,000,000.00** | **5,000,000.00** | **0.00** | 100% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,000,000.00 | 5,000,000.00 | 0.00 | 100% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,842,600.00** | **27,189,440.00** | **-1,653,160.00** | 94% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,842,600.00 | 27,189,440.00 | -1,653,160.00 | 94% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,842,600.00 | 17,234,712.00 | -1,607,888.00 | 91% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,000,000.00 | 9,954,728.00 | -45,272.00 | 100% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,746,518,000.00** | **1,229,321,202.97** | **-517,196,797.03** | 70% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,389,352,400.00** | **1,169,650,468.97** | **-219,701,931.03** | 84% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,389,352,400.00 | 1,169,650,468.97 | -219,701,931.03 | 84% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **357,165,600.00** | **59,670,734.00** | **-297,494,866.00** | 17% |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 357,165,600.00 | 58,995,464.00 | -298,170,136.00 | 17% |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 675,270.00 | -675,270.00 | |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **1,484,976,935.49** | **(1,484,976,935.49)** | |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **1,614,969,960.81** | **(1,614,969,960.81)** | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 65.00 | 65.00 | 0.00 | 100% |
| 620001 | Удирдах ажилтан | 03.00 | 03.00 | 0.00 | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 41.00 | 41.00 | 0.00 | 100% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 21.00 | 0.00 | 100% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,488,254,912.00** | **9,285,568,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,988,254,912.00** | **9,285,568,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,607,518,512.00** | **3,264,472,800.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **714,045,200.00** | **1,500,000,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 714,045,200.00 | 1,500,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **893,473,312.00** | **1764472800.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 893,473,312.00 | 1,764,472,800.00 |
| **211** | **ХҮҮ** | **6,380,736,400.00** | **6,021,095,500.00** |
| **2112** | **Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр** | **6,380,736,400.00** | **6,021,095,500.00** |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 6,380,736,400.00 | 6,021,095,500.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,500,000.00** | **00.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,500,000,000.00 | 00.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **12,488,254,912.00** | **9,285,568,300.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **12,488,254,912.00** | **9,285,568,300.00** |
| 131103 | ЗГНХ.ЗДНХөрөнгө.түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 278,205,184.00 | 649,205,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,210,049,728.00 | 8,636,363,300.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "*Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.*" гэж заасны дагуу Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилт, алба хаагчдад үр дүнгийн урамшуулал, хоол унааны мөнгөтэй холбоотой асуудал, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын гүйцэтгэл болон анхан шатны баримтын бүрдэл, төсвийн хэмнэлтийн талаарх МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын аудитын хоёрдугаар хэлтсийн аудитор Б.Тэгшлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 01/97 дугаар албан бичгээр ирүүлсэн байна. Тус газрын нэр нь 2022 оны 2 сараас эхлэн "Нийслэлийн Өмчийн харилцааны газар" гэж өөрчлөгдсөн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: "*Нийслэлийн Өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд оршино*. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх" гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын үйл ажиллагааны чиглэл:

Тус газар нь "төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн тайланг боловсруулах" үндсэн 1 зорилт бүхий 2 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилт 91.8 хувьтай байна

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар: Тус байгууллагын үйл ажиллагаанд НЗД-ын дотоод аудитын газраас 2020 онд аудитын хяналт хэрэгжүүлсэн бөгөөд тайлант онд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 45,911,222.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 688,668.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 516,501.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,902,319.4 мянган төгрөгөөр буюу 19.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, өр төлбөр зээлийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,484,976.9 | 1,614,969.9 | 129,993.0 |
| Авлага | 372,140.9 | 532,518.1 | 160,377.2 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 48,798.2 | 41,759.6 | (7,038.5) |
| Үндсэн хөрөнгө | 38,894,184.6 | 30,708,533.4 | (8,185,651.1) |
| **Нийт хөрөнгө** | **40,800,100.6** | **32,897,781.2** | **(7,902,319.4)** |
| **Нийт өр төлбөр** | **967,213.6** | **214,053,653.5** | **213,086,439.8** |
| Үүнээс: Богино хугацаат өр төлбөр | 718,538.1 | 75,552,496.5 | 74,833,958.4 |
| Урт хугацаат өр, зээл | 248,675.4 | 138,501,157.0 | 138,252,481.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 39,832,887.0 | (181,155,872.2) | (220,988,759.2) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **40,800,100.6** | **32,897,781.2** | **(7,902,319.4)** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,614,969.9 мянган төгрөг болж 129,993.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь барьцаа дансанд хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл санхүүжилтийг байршуулсан, болон орон сууцны төлөлтийн мөнгө орж ирсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 532,518.1 мянган төгрөг болж 160,377.2 мянган төгрөгөөр өссөн нь ногдол ашгийн авлага 34,000.0 мянгаар бүрэн барагдсан ч, түрээсийн авлага болон төлбөр акт тогтоогдсонтой холбоотой байна.

Тайлант онд 311,466.5 мянган төгрөгийн түрээсийн авлага үүсч 121,070.1 мянган төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 528,537.3 мянга, алба хаагчтай холбоотой 3,980.8 мянга, нийт 532,518.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Үүнээс цаашид барагдах боломжгүй эрсдэлтэй 2014 оноос өмнө үүссэн 15,442.8 мянган төгрөгийн найдваргүй авлагыг холбогдох шийдвэрийг гаргуулж данснаас хасаж найдваргүй авлагын зардлаар бүртгээгүй ба өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41,759.6 мянган төгрөг болж 7,038.5 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 30,708,533.4 мянган төгрөг болж 8,185,651.1 мянган төгрөгөөр буурсан барилга байгууламж, нийтийн эзэмшил, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг эзэмшигч ашиглагч байгууллагуудад нь шилжүүлсэнтэй холбоотой.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 41,627.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж орлогод авсан. НЗД-ын захирамж, НӨАУГ-ын даргын тушаал шийдвэрийг үндэслэж

641,800.7 мянган төгрөгийн үнэгүй төлбөргүй хөрөнгө шилжиж ирснийг бүртгэлд тусгасан.

Тайлант хугацаанд нийт 7,930,763.5 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан нь НӨХК-ын тогтоолоор хувьчлагдсан 62,733.5 мянга, ашиглагч байгууллагад шилжүүлсэн 7,852,901.4 мянга, акталж устгасан 15,128.6 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг хөрөнгийн ангиллаар нь тодруулан дурьдвал:

Барилга, байгууламж данснаас НЗД-ын 2016 оны А/227 тоот захирамж НӨАУГ-ын даргын 2021 оны А/489 тоот тушаалаар шилжүүлсэн УБ Бизнес хөгжлийн төв 7,457,777.2 мянга, НӨХК-ын 2020 оны 04, 11 дугаар тогтоол, НӨАУГ-ын 2021 оны А/521, А/522 тоот тушаал шийдвэрүүдийг үндэслэн хувьчлагдсан СБД 16-р хороо Мандам ӨЭМТ барилга(хуучин) 17,665.2 мянга, Шуудангийн 26-р салбар 45,068.3 мянга, нийт 7,520,510.7 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Нийтийн эзэмшлийн дансанд бүртгэлтэй байсан 249,696.0 мянган төгрөгийн БЗД 4-р хороо Хөл бөмбөгийн талбайг НӨАУГ-ын даргын А/682 тоот тушаалаар шилжүүлэн бүртгэлээс хассан. (*НТАГ-ын завсрын аудитаар зөвлөмжилсөн*)

Авто тээврийн хэрэгсэл дансанд тусгай зориулалтын 18,368.0 мянган төгрөгийн 2, суудлын 8,411.4 мянган төгрөгийн автомашиныг НЗД-ын 2021 оны А/219, А/720 тоот захирамж, НӨАУГ-ын даргын А/210, А/684 тушаалаар балансаас балансад шилжүүлэн авч, бүртгэсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр цахилгааны халаалтын их засварт 23,470.5 мянга, бусад 1,166.0 мянга, нийт 24,636.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлжүүлсэн байна. НЗД-ын 2016 оны А/227 тоот захирамж, НӨАУГ-ын 2021 оны А/489 тоот тушаалаар шилжүүлсэн 113,318.8 мянга, НӨАУГ-ын 2021 оны А/437 тоот тушаалаар акталсан 15,128.7 мянга, нийт 128,447.5 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан.

Тавилга эд хогшил данснаас НЗД-ын 2016 оны А/227 тоот захирамж, НӨАУГ-ын 2021 оны А/489 тоот тушаалаар 32,109.2 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлж, бүртгэлээс хассан байна.

Тайлант онд өр төлбөр дансны үлдэгдэл 214,053,653.5 мянган төгрөг болж 213,086,439.8 мянган төгрөгөөр өссөн нь гадаад зээл, зээлийн хүүгийн өр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд онцлох үйл ажиллагаа шийдвэрээс шалтгаалан нийт өр төлбөр бүртгэл, тайлант үеийн зардал, эздийн өмч, данс бүртгэлд томоохонд өөрчлөлт орсон байна.

МУ-ын ЗГ болон Америкийн Нэгдсэн улсын Мянганы сорилтын корпорацийн хооронд байгуулсан “Мянганы сорилтын компакт гэрээ” хүчин төгөлдөр болоход тавигдаж байгаа урьдчилсан болзолт нөхцөлийг хангах хүрээнд “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайланд бүртгэлтэй урт хугацаат зээл 139,641,243.3 мянган төгрөг, зээлийн хүүгийн хуримтлагдсан өр 69,686,254.1 мянга, нийт 209,327,497.4 мянган төгрөгийн өр төлбөрийг холбогдох шийдвэрүүдийг үндэслэн балансаас балансад шилжүүлэн НӨАУГ-ийн тайлан бүртгэлд тусгасан байна. Тайлант онд зээлийн хүүд 4,752,428.4 мянга, валютын ханшийн зөрүү 1,314,051.2 мянган төгрөгийн олзыг тооцож хүлээн зөвшөөрч үндсэн зээлээс буурч, нийт 212,765,874.6 мянган төгрөг болсон байна.

Өмнөх онуудад үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой 22 иргэн, аж ахуйн нэгжийн нийт 173,964.9 мянган төгрөгийн урт хугацаат өр байна.

Барьцаа дансанд тайлант онд 10 ажлын 498,288.8 мянган төгрөгийн барьцаа нэмэгдэж, 22 аж ахуйн нэгжид 767,058.0 мянган төгрөгийн олгон чөлөөлж, үлдэгдэл 65 аж ахуйн нэгжийн 825,547.8 мянган төгрөгийн барьцааны өглөг үлдсэн байна.

Насжилтаар харуулбал 2004 оны 97,898.6 мянга, 2017 оны 924.9 мянга, 2018 оны 9,355.4 мянга, 2019 оны 182,937.9 мянга, 2020 оны 36,142.0 мянга, 2021 оны 498,288.8 мянган төгрөг.

Хяналт шалгалтаар тогтоосон төлбөрийн актын өглөг 288,266.2 мянган төгрөг үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 39,832,887.1 мянган төгрөгөөс 220,988,759.2 мянгаар буурсан нь гадаад урт хугацаат зээл, зээлийн хүүгийн өртэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 30,671,389.0 мянган төгрөгөөр буюу 33.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь өмнөх оноос орон нутгийн төсвөөс ОНӨААТҮГ-т өгөх хөрөнгийн санхүүжилт 6,375,855.6 мянгаар, нэмэлт санхүүжилтийн орлого 3,202,686.6 мянгаар, өмч хувьчлалын орлого 20,565,203.2 мянгаар, түрээсийн орлого 282,446.2 мянгаар, өөрийн орлого 589.7 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 393,605.5 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 35,231,368.8 мянган төгрөгөөр буюу 58.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төрийн өмчит байгууллагад өгөх татаас, дотоод зээлийн үйлчилгээний төлбөр, хөрөнгийн зардал, цалин нэмэгдэл НДШ, зэрэг зардлууд 63.08 хувиар хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Харин тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, гадаад зээлийн хүүгийн зардал, үндсэн хөрөнгө худалдсаны гарз зэрэг зарлагууд өссөн байна. Ковид-19 цар тахалтай холбоотой хамгаалалтын хэрэгсэл, дархлаажуулалтын бүтээгдэхүүн худалдаж авч зарцуулсан, цахим сургалт зохион байгуулахад онлайн эрх үйлчилгээ авсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү гадаад зээл зээгийн хуримтлагдсан хүүтэй холбоотой 202,839,188.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт:

Тус газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийслэлийн төсвөөс 1,935,015.7 мянгаар, өөрийн орлогыг 357,165.6 мянгаар нийт

2,292,181.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,292,181.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 546,663.3 мянган төгрөгөөр буюу 23.8 хувиар бууруулж санхүүжилтийг 1,389,352.4 мянга, өөрийн орлогыг 357,165.6 мянга, нийт 1,746,518.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд, цалин хөлс нэмэгдэл урамшуулал болон НДШ-ийн зардлыг 40,659.8 мянга, байр ашиглалт тогтмол зардлыг 12,053.5 мянга, бараа хангамжийн материалын зардлыг 17,315.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр болон бараа үйлчилгээний бусад зардал 267,214.5 мянга, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын олговрыг 14,708.0 мянга, нийт 546,663.3 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,389,352.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 357,165.6 мянга, нийт 1,746,518.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,389,352.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 1,103,056.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 138,562.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого 357,165.6 мянган төгрөг зарцуулахаар төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 59,670.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан ба орлогын төлөвлөгөө 297,494.9 мянган төгрөгөөр буюу 83.3 хувиар тасарсан байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,229,321.2 мянган төгрөг буюу 88.4 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 150,957.9 мянга, байр ашиглалттай тогтмол зардлаас 2,351.9 мянга, хангамж материалын зардлаас 3,467.4 бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 358,766.1 мянга, бусад урсгал шилжүүлгээс 1,653.1 мянган төгрөгөөр тус тус төсвийг дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:**

НИТХ-ын 2020 оны 02/11 дүгээр тогтоолоор нийт 2,278,336.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 3,071,426.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөг 134.8 хувиар буюу 793,089.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 2* Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|
| Түрээсийн орлого | 2,000,000.0 | 2,478,002.5 | 478,002.5 | 123.9% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Өмч хувьчлал | - | 186,106.3 | 186,106.3 | - |
| Ногдол ашиг | 278,336.8 | 289,390.2 | 11,053.4 | 104.0% |
| Акталсан хөрөнгө борлуулсны орлого | - | 117,927.1 | 117,927.1 | - |
| **Нийт дүн** | **2,278,336.8** | **3,071,426.1** | **793,089.3** | **134.8%** |

Төсвийн орлогын төлөвлөгөө 34.8 хувиар давалттай байгаагаас түрээсийн орлого 23.9 хувиар давалттай байна. Энэ нь Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хийсэн хяналт шалгалтын үр дүнд 73.0 сая, шууд түрээсийн 19 гэрээний үнийг түрээсийн жишигт нийцүүлж 5 хувиар өсгөж гэрээг шинэчилсэн, сургуулиудын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж үдийн цайны газрын түрээс орж ирсэн бөгөөд гол шалтгаан нь 2020 онд тасарсан орлогын 17.2 хувийг нөхөн барагдуулж ажилласантай холбоотой байна. Шүүхийн шийдвэрээр СБД-ийн 10 дугаар хорооны халуун усны барилгын хувьчлалын орлого орж ирж төсөвт төвлөрүүлсэн. Ноогдол ашгийн орлого 4 хувиар даван биелэгдсэн нь НИТХ-ын 2021 оны 8 сарын 17-ны өдрийн 92 дугаар тогтоолоор батлагдсан 2020 онд ашигтай ажилласан 3 НӨҮГ-аас 221.7 сая, өмнөх оны авлага 67.6 сая төгрөг нийслэлийн төсөвт төвлөрсөнтэй холбоотой.

### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас Нийслэлийн ЗД-ын 2021 оны А/58 дугаар захирамжаар "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ын 2021 оны үйл ажиллагаанд 615,267.8 мянга, "Улаанбаатар хотын хөгжлийн корпорац" ХК-нд 500,000.0 мянга, нийт 1,115,267.8 мянган төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг авч, дамжуулан олгосон байна. НЗД-ын 2021 оны А/871 тоот захирамжаар "Улаанбаатар спорт менежмент" ХХК-ны дүрмийн сан 1,500,000.0 мянга, Нийслэлийн ЗД-ын 2021 оны А/481 тоот захирамжаар "Нийслэлийн орон сууцны корпорац" ХК-ны түрээсийн орон сууцны хүүгийн төлбөрт 4,122,342.6 мянга, Нийслэлийн ЗД-ын А/872 тоот захирамжаар "Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн орон нутгийн зээлийн" төлбөрт 1,898,752.9 мянга, Нийслэлийн ЗД-ын А/478 тоот захирамжаар нөөц сангаас гэрээт ажлын санхүүжилт 649,205.0 мянга, нийт 9,285,568.3 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нийслэлийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа болон дүрмийн санг нэмэгдүүлэх, түрээсийн сууцны хүүгийн төлбөр, нийтийн тээврийн парк шинэчлэлтийн зээлийн төлбөрт нийслэлийн төсвөөс олгосон нийт 8,636,363.3 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд дамжуулан олгосон, ЗД-ын нөөц хөрөнгөөс авсан санхүүжилтээс хөрөнгө нийлүүлэх гэрээт ажлын хөлсөнд 649,205.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нийслэлийн 2021 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлаас 7 ажлын 1,424,931.9 мянган төгрөгийг эрх шилжүүлсэн авч, хөрөнгийн зардалд зарцуулсан

байна. /Үнээс хэрэгжээгүй гэрээт ажлын санхүүжилт 410,100.0 мянган төгрөгийг барьцаа дансанд татан байршуулсан байна./

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**Асуудлыг онцолсон хэсэг:**

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад дараах байдалтай байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 1 сарын 27-ны өдрийн 26 дугаар тогтоол болон Нийслэлийн ЗД-ын 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/198 дугаар захирамжийн дагуу УСУГ-ын урт хугацаат гадаад зээл, зээлийн хүүгийн хуримтлагдсан өр төлбөр 209,327.4 сая төгрөгийг тус газарт шилжүүлснийг санхүүгийн байдлын тайланд, тайлант оны хүүгийн зардал 4,752.4 сая, ханшийн зөрүүнээс олз 1,314.0 сая, нийт 6,066.4 сая төгрөгөөр үүсч үр дүнгийн болон өмчийн өөрчлөлтийн тайлант томоохон өөрчлөлт орсныг тайлагнасан байна.
- 2014 онд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад олгосон 30 айлын орон сууцны 1,725.6 сая төгрөгийн зээлийн гэрээ дүгнэгдээгүй, комиссын шийдвэр гараагүйгээс төлөлт зогсож, зээлийн үлдэгдлийн 54 хувь буюу 936.2 сая төгрөгийг холбогдох албан хаагчид төлөөгүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.
- Он удаан жил (*2013 оноос өмнөх 15.4 сая, 2014 оных 109.3 сая, 2015 оных 20.0 сая, 2016 оны 24.0 сая, 2017 оны 6.1 сая, 2018 оны 11.0 сая, 2019 оны 125.2 сая, 2020 оны 14.9 сая төгрөг*) болсон түрээсийн авлага, барьцааны (*2004 онд 97.8 сая, 2017 онд 0.9 сая, 2018 оны 9.3 сая төгрөг*) өглөгийг барагдуулах талаар холбогдох шийдвэрийг гаргуулаагүй.
- Нэмэлт санхүүжилтийн дансаар орсон нийт 9,285.5 сая төгрөгийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

**Бусад асуудлын хэсэг:**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар нь 2021 онд нийт 12,406.1 сая төгрөгийн 608 гүйлгээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 509.1 сая төгрөгийн 20 мэдээллийг байршуулж, 1,664,396.5 мянган төгрөгийн 366 гүйлгээг хугацаа хоцроож, 1,845,012.2 мянган төгрөгийн 25 гүйлгээг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий орлогын 1, зарлагын 6 гүйлгээг (*136,346.5 мянган төгрөг*), авлага, өглөг зээлийн өрийн 359 мэдээллийг (*1,528,050.0 мянган төгрөг*) тус тус хугацаа хоцроож байршуулж, худалдан авалт, ажил үйлчилгээний төлбөрийн 24 гүйлгээг (*1,845,012.2 мянган төгрөг*) мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл Шилэн дансны мэдээлэл 6.4.*"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:"*, 6.4.4.*"таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"*; 6.2.4.*"хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт;"* 6.3.7. *"хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, обьект тус бүрээр;"* заалтыг хэрэгжүүлээгүй *байна*.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зөрчлийг арилгуулах албан шаардлага өглөө.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ЗГ-ын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас *(цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ашиглалтын зардал ... гэх мэт)* бусад бүх төрлийн зардлыг 10-аас доошгүй хувь буюу 4,064.0 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаагүй байна. Энэ нь ЗГ-ын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 *"үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*" заалтыг хэрэгжүүлээгүй;

- Тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн ажилтны орон тоонд томилгоо хийж 1 хүн ажиллуулж 4,309.7 мянган төгрөгөөр төсвийг хэмнээгүй ажилласан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2 "*шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;*" заалтыг хэрэгжүүлээгүй;

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Зөрчлийг арилгуулах албан шаардлага өглөө.

Тус газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1,725,696.0 мянган төгрөгийн Буянт-Ухаа-1 орон сууцны хорооллын 30 айлын орон сууцыг нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчтай 2015 онд НӨХГ болон холбогдох нийслэлийн төр захиргааны байгууллагатай 3 жилийн хугацаатай төлбөрийг төлж барагдуулах нөхцөлтэй "Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад орон сууц худалдах гэрээ"-г байгуулжээ. Гэрээний дагуу 2021 оны байдлаар нийт 789,422.2 мянган төгрөгийг төрийн албан хаагчид Нийслэлийн төрийн сангийн "Улаанбаатар орон сууц-орлого" 200000986 тоот дансанд төвлөрүүлсэн байна. Гэтэл гэрээний хугацаа 2018 онд дууссан байхад төсвөөс олгосон төлбөрийн үлдэгдэл 936,273.8 мянган төгрөгийг холбогдох албан хаагчдаас барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Энэ талаар Нийслэлийн Дотоод аудитын газраас гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж өгч байсныг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь "Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад орон сууц худалдах гэрээ"-ний 4.3. *"Орон сууцны 30 хувийн төлбөрийг сар бүр төлөх бөгөөд 3 жилийн дотор барагдуулахаар тооцож гаргана."*, 4.4. *"Албан хаагч Орон сууны 30 хувийн төлбөрийг төлж дууссан өдрөөс хойш 3 сарын хугацаанд 70 хувийн төлбөрийг бүрэн төлж барагдуулна."* заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах,асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх албан шаардлага өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн болон ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн зарим заалтуудтай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 3.10.1.Завсрын аудитын үр дүн

2021 оны III улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар шинээр ирсэн ашиглагдаж байгаа автомашиныг эд хариуцагчид хариуцуулан картжуулаагүй 7,029.2 мянга, шатахуун олголтыг тухай бүрд нь НББ-д тусгаагүй 465.0 мянга, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй бодитоор оршин байхгүй барилга, худаг 252,026.9 мянга, болон УБ даатгалын хөрөнгө оруулалт 40,000.0 мянга, НСТӨ-ны 706,172.7 мянган төгрөгийн газар эзэмшлийн гэрчилгээгүй, газар ашиглалтын гэрээгүй зэрэг нийт 1,005,693.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 3 зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд: УБ даатгалын хөрөнгө оруулалттай холбоотой хөрөнгийг холбогдох газарт албан хүсэлт хүргүүлсэн, хуучнаар Солонго ресторанны 238,011.6 мянган төгрөгийн барилгын асуудал шүүхэд нэхэмжлэх гаргасан байна.

#### 3.10.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 361,444.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгснөөс шилэн данстай холбоотой болон шатахуун тээврийн зардалтай холбоотой 2 албан шаардлага, и-баримтгүй гүйлгээ гаргасан 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 18.4 хувьтай байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 8,693.1 | - | - | 2 | 8,693.1 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 352,751.7 | 1 | 66,325.3 | 2 | 286,426.4 | 81.2 |
| **Нийт дүн** | **5** | **361,444.8** | **1** | **66,325.3** | **4** | **295,119.5** | **81.6** |

Өмнөх оны аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул давтан гаргах байх албан шаардлага хүргүүлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал нь хөрөнгө оруулалтын ажил, төсөл хөтөлбөр, худалдан авах ажиллагаа, хөрөнгийн ашиглалт,хадгалалт хамгаалалт, орлого бүрдүүлэлтийн түүний биелэлтийн талаар хамруулах болно.

Ковид-19 цар тахлын хатуу хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотой цахимаар ажилласан болон цаг хугацаа хязгаарлагдсан байдлаас шалтгаалан зарим зардал болон хөрөнгийн үлдэгдэлд биет тестийн горимыг хэрэгжүүлээгүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 338,430.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 17,093.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 306,637.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 14,700.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд залруулга хийх алдаа илэрлээ болно.

### 4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд хийгдсэн зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний 300,942.4 мянган төгрөгийн төлбөрийг и-баримтгүй шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2. *"бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно;"* заалт, 17.6.*"Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй"*, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.*" заалтуудыг хэрэгжүүлээгүй.

2. Албан ажлын болон дуудлагын авто машиныг хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад байхгүй орлогч дарга албан тушаалтан авто машин унаж, дуудлагаар 1,844.8 мянга, байгууллагын автомашинаар 3,850.0 мянга, нийт 5,694.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нийслэлийн Засаг даргын "Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай" 2013 оны А/480 дугаар захирамжийн хавсралтын 2 дахь хавсралтад заасныг хэрэгжүүлээгүй болон өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

**4.3 Төлбөрийн акт**

1. Улирлын ажлын гүйцэтгэлээр олгох үр дүнгийн урамшуулалд 16,278.3 мянга, илүү цагийн нэмэгдэл хөлс 317.4 мянга, ажилласан жилийн нэмэгдэл 461.7 мянга, албан тушаалын цалингийн зөрүү 35.9 мянга, нийт 17,093.3 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4. "*үнэн зөв байх;*", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;*", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 "*Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.*" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоолоо.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***4.4.1 Цалингийн зардлын данстай холбоотой асуудал:***

*Илрүүлэлт:* Нэг удаагийн шагнал урамшуулал, тэтгэмж 6,200.0 мянган төгрөгийг цалингийн сангийн зардлаас олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;*" заалт, Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 2021 оны 190 дүгээр тушаалын холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй.

*Өгсөн зөвлөмж:* Цалингийн зардлаас бусад төрлийн зардлыг зарцуулахгүй байх түүний хэрэгжилтэд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

***4.3.2 Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал:***

*Илрүүлэлт:* Байгууллагын цахим хуудсыг (вэф сайт) шинэчлэл хөгжүүлэлт сайжруулалтын зардал 8,500.0 мянган төгрөгийг биет бус хөрөнгөнд бүртгээгүй, зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "*Үнэн зөв байх;*" заалтыг хэрэгжүүлээгүй.

*Өгсөн зөвлөмж:* Ирээдүйд үр өгөөж өгөх хөрөнгийг бүртгэлжүүлж, үүуд зардлаар бүртгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:** | | | | | | | | | | | |
| 1 | Тайлант хугацаанд хийгдсэн зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний төлбөрийг И баримтгүй шилжүүлсэн | 1 | 300,942.4 | | | | | 1 | 300,942.4 | | |
| 2 | Нэг удаагийн шагнал урамшуулал, тэтгэмжийг цалингийн сангийн зардлаас олгосон. | 1 | 6,200.0 | | | | | | | 1 | 6,200.0 |
| 3 | Албан ажлын болон дуудлагын авто машиныг хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад байхгүй орлогч дарга албан тушаалтан авто машин унаж, тээврийн зардал гаргасан | 1 | 5,694.8 | | | | | 1 | 5,694.8 | | |
| 4 | Улирлын ажлын гүйцэтгэлээр олгох үр дүнгийн урамшуулалд 16,278.3 мянга, илүү цагийн нэмэгдэл хөлс 317.4 мянга, ажилласан жилийн нэмэгдэл 461.7 мянга, албан тушаалын цалингийн зөрүү 35.9 мянга, нийт 17,093.3 мянган төгрөг илүү тооцож олгосон | 1 | 17,093.3 | | | 1 | 17,093.3 | | | | |
| 5 | Байгууллагын вэб сайт хөгжүүлэлт шинэчлэлийн зардлыг биет бус хөрөнгөнд бүртгээгүй, зарлагаар хаасан. | 1 | 8,500.0 | | | | | | | 1 | 8,500.0 |
| **Дүн** | | **5** | **338,430.5** | | | **1** | **17,093.3** | **2** | **306,637.2** | **2** | **14,700.0** |
| **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:** | | | | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий орлогын 1, зарлагын 6 гүйлгээг (*136,346.5 мянган төгрөг*), авлага, өглөг зээлийн өрийн 359 мэдээллийг (*1,528,050.0 мянган төгрөг*) тус тус хугацаа хоцроож байршуулж, худалдан авалт, ажил үйлчилгээний төлбөрийн 24 гүйлгээг (*1,845,012.2 мянган төгрөг*) мэдээлээгүй | 1 | 3,509,408.7 | | | | | 1 | 3,509,408.7 | | |
| 2 | Цалин хөлс, НДШ болон нэг удаагийн тэтгэмж, байрны түрээсийн зардлаас бусад төрлийн | 1 | 4,064.0 | | | | | 1 | 4,064.0 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зардлын батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй ажилласан. | | | | | | | | | | |
| 3 | Тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн ажилтны орон тоонд томилгоо хийж 1 хүн ажиллуулж 4,309.7 мянган төгрөгөөр төсвийг хэмнээгүй ажилласан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1..2 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй. | 1 | 4,309.7 | | | | | 1 | 4,309.7 | | |
| 4 | Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад олгосон Буянт Ухаа-1 орон сууцны хорооллын 30 айлын орон сууцны зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон байхад гэрээний хугацааг сунгаагүй, төлбөрийн үлдэгдлийг холбогдох албан хаагчдаар төлүүлэх арга хэмжээ аваагүй. | 1 | 936,273.8 | | | | | 1 | 936,273.8 | | |
| **Дүн** | | **4** | **4,454,056.2** | | | | | **4** | **4,454,056.2** | | |
| **Нийт дүн** | | **9** | **4,792,486.7** | | | **2** | **17,093.3** | **6** | **4,760,693.4** | **2** | **14,700.0** |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар 319/А0270181 Улаанбаатар хот

НТӨТ-2022/2 89/ИН-СР-Т2И5

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Өмч, ашиглалт удирдлагын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

- Тус газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1,725,696,000.00 (*нэг тэрбум долоон зуун хорин таван сая зургаан зуун ерэн зургаан мянга*) төгрөгийн Буянт-Ухаа-1 орон сууцны хорооллын 30 айлын орон сууцыг нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчтай 2015 онд НӨХГ болон холбогдох нийслэлийн төр захиргааны байгууллагатай 3 жилийн хугацаатай төлбөрийг төлж барагдуулах нөхцөлтэй "Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад орон сууц худалдах гэрээ"-г байгуулжээ. Гэрээний дагуу 2021 оны байдлаар нийт 789,422,118.00 (*долоон зуун наян есэн сая дөрвөн зуун хорин хоёр мянга нэг зуун арван найм*) төгрөгийг төрийн албан хаагчид Нийслэлийн төрийн сангийн "Улаанбаатар орон сууц-орлого" 200000986 тоот дансанд төвлөрүүлсэн байна. Гэтэл гэрээний хугацаа 2018 онд дууссан байхад төсвөөс олгосон төлбөрийн үлдэгдэл 936,273,881.00 (*есөн зуун гучин зургаан сая хоёр зуун далан гурван мянга найман зуун наян нэг*) төгрөгийг холбогдох албан хаагчдаас барагдуулах арга хэмжээ аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. Энэ талаар Нийслэлийн Дотоод аудитын газраас гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж өгч байсныг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "*үнэн зөв байх*", "Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад орон сууц худалдах гэрээ"-ний 4.3. *"Орон сууцны 30 хувийн төлбөрийг сар бүр төлөх бөгөөд 3 жилийн дотор барагдуулахаар тооцож гаргана."*, 4.4. *"Албан хаагч Орон сууны 30 хувийн төлбөрийг төлж дууссан өдрөөс хойш 3 сарын хугацаанд 70 хувийн төлбөрийг бүрэн төлж барагдуулна."* Заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар

002041069

тушаалаар баталсан *“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”*-ын 4.2.1.11. “*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад олгосон 30 айлын орон сууцны зээлийн төлбөрийн үлдэгдлийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, төсвөөс олгосон төлбөрийн үлдэгдлийг холбогдох албан хаагчдаар төлүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга М.Баяраа, ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1] :

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар 318/А0270181 Улаанбаатар хот

НТЭГ-2022/286/НА-СА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Өмч, ашиглалт удирдлагын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

- Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг 10-аас доошгүй хувь буюу 4,064,000.00 (дөрвөн сая жаран дөрвөн мянган) төгрөгөөр, тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн ажилтны орон тоонд томилгоо хийж 1 хүн ажиллуулж 4,309,700.00 (дөрвөн сая гурван зуун есөн мянга долоон зуун) төгрөгийн цалин олгож төсвийг тус тус хэмнэж ажиллаагүй байна. Эдгээр зөрчлүүд нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 *"үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зөрдөл, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*", 1.2 *"шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;*" заалтыг хэрэгжүүлээгүй;

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.11. "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын зарим заалтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

0000041066

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга М.Баяраа, ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1] :

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар 3/7/1/1027018/ Улаанбаатар хот

НТӨГ-2022/286/НЛ-СА-ТМ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Өмч, ашиглалт удирдлагын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий 136,346,500.00 төгрөгийн орлогын 1, зарлагын 6 гүйлгээг, 1,528,050,000.00 төгрөгийн авлага, өглөг зээлийн өрийн 359 мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулж, 1,845,012.2 мянган төгрөгийн худалдан авалт, ажил үйлчилгээний төлбөрийн 24 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл Шилэн дансны мэдээлэл 6.4.*"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:"*, 6.4.4.*"таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"*; 6.2.4.*"хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт;"* 6.3.7. *"хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр;"* заалтуудыг хэрэгжүүлээгүй;

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.11. "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроож байршуулсан болон өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг цаашид анхаарч арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга М.Баяраа, ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэг нарт хариуцуулав.

002041063

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1] :

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар 3/6 / 10270181 Улаанбаатар хот

НТАГ-2022/286/ИМ-СА-7473

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Өмч, ашиглалт удирдлагын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

- Албан ажлын болон дуудлагын авто машиныг хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад байхгүй орлогч дарга албан тушаалтан авто машин унаж, дуудлагаар 1,844,800.00 төгрөг, байгууллагын автомашинаар 3,850,000.00 төгрөг, нийт 5,694,800.00 (таван сая зургаан зуун ерэн дөрвөн мянга найман зуун) төгрөгийн шатахуун зарцуулсан, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй, зөрчлийг давтан байна. Энэ нь Нийслэлийн Засаг даргын "Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай" 2013 оны А/480 дугаар захирамжийн хавсралтын 2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.11. "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Албан ажлын болон дуудлагын авто машиныг хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад байхгүй албан тушаалтан авто машин хэрэглэж шатахуун зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга М.Баяраа, ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэг нарт хариуцуулав.

002041060

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1] :

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 сарын 25 өдөр        Дугаар 3/5/ 10270 181        Улаанбаатар хот

НТӨГ-2022/986/ НӨ-СА-ТНЗ

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн Өмч, ашиглалт удирдлагын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

- Тайлант хугацаанд хийгдсэн зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний 300,942,400.00 (гурван зуун сая есөн зуун дөчин хоёр мянга дөрвөн зуу) төлбөрийг и-баримтгүй шилжүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт *"Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ"* заалтуудыг хэрэгжүүлээгүй;

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.11. *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Худалдан авалтын анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

002041057

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга М.Баяраа, ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1] :

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар